



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 618

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж бий болсон, нийт 15,991,875,249.00 (арван таван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая найман зуун далан таван мянга хоёр зуун дөчин ес) төгрөгийн үнэ бүхий барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Прокурорын байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, хавсралтад заасан Аймгийн Прокурорын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг бүртгэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

130002686  
28-r\_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 1 дугаар сарын 28-ны өдрийн  
018 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН  
ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Төрийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Хэнтий аймгийн Прокурорын газрын контор-ын барилга (Хэнтий, Хэрлэн сум өөрийн эзэмшлийн газар дээр)	Албаны зориулалттай, зоорьтой, 3 давхар, тэнхлэгээрээ 28.0м*13.0м,	5,384,899,998.00	2023.11.20	2023/14	Хэнтий аймаг дахь Аймгийн Прокурорын газар
2	Архангай аймгийн Прокурорын газрын контор-ын барилга (Архангай аймаг, Эрдэнэбулган сум өөрийн эзэмшлийн газар дээр)	Албаны зориулалттай, зоорьтой, 3 давхар, тэнхлэгээрээ 28.0м*13.0м,	4,874,500,001.00	2023.04.27	2023/01	Архангай аймаг дахь Аймгийн Прокурорын газар
3	Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын контор-ын барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 30.0м*37.5м, 15 ортой,	5,732,475,250.00	2022.06.24	БА-149/2022	Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газар
			15,991,875,249.00			
НИЙТ ДҮН			(арван таван тэрбум есөн зуун ерэн нэгэн сая найман зуун далан таван мянга хоёр зуун дөчин ес)			